



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А)114

Хэрлэн сум

“Өндөрхаан сүү” орон нутгийн өмчит
аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг
татан буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4, Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арвандолоодугаар хуралдааны 2023 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.2013 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй, цаашид хэвийн ажиллах боломжгүй гэж үзсэн Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 80/A2370454 дугаартай албан шаардлагын дагуу “Өндөрхаан сүү” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг татан буулгасугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан татан буугдсан байгууллагын эд хөрөнгө, үйл ажиллагаатай холбогдсон зохион байгуулалтын арга хэмжээг зохих хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

